

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2019 ОНЫ 8 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Аймгийн хэмжээнд 141,9 мянга га талбайд улаан буудай тариалснаас 4186 га талбай ургац алдаж, 1640 га талбай тэжээлд шилжиж, урьдчилсан ургац тогтоолтоор 133,7 мянга га талбайгаас 11.4 цн буюу 157,3 мянга тн улаанбуудай хураан авах төлөвтэй байна.

Өвөлжилтийн бэлтгэлийг хангах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын албан даалгаврыг гаргаж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. 9-р сарын 2-ний өдөр аймгийн Онцгой комисс хуралдаж аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын дарга нарын мэдээллийг сонгож, иргэдийн тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх үүднээс Сүхбаатар сумын 7-р багийн 1-р 60 айлын дээврийн засвар, Алтанбулаг сумын 64 айлын орон сууц, 1-6 дугаар байрны талаар гаргасан иргэдийн хүсэлтийг шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авахаар шийдвэрлэлээ.

ADRA Олон Улсын байгууллага Германы эдийн засгийн яамны санхүүжилтээр Органик хөдөө аж ахуйн түншлэл төслөөс 11 сумын 31 хоршоо, 912 ногоочинг сонгон төслийг амжилттай хэрэгжүүлж, анхны хамтын баталгаажуулалтын байгууллагатай болсон. Төсөлтэй хамтран Орхон, Ерөө, Хангай үүлдрийн хонийг үржүүлэх, хамгаалах мах, ноосны чанарыг нэмэгдүүлж, малчдын ашиг орлогыг дээшлүүлэх, ногоочдын борлуулалтад хамтран ажиллах уулзалтыг 7-р сарын 31-нд тус аймагт хийлээ.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын дарга Фэн Юйжэнь тэргүүтэй төлөөлөгчид тус аймагт 8-р сарын 27-ны өдөр албан ёсны айлчлал хийсэн. Айлчлалын гол зорилго нь хоёр талын найрамдалт харилцааг бэхжүүлэх, аж ахуйн нэгжүүдийн хамтран ажиллах эхлэлийн тавихад чиглэгдсэн бөгөөд аймгийн Засаг дарга, ӨМӨЗО-ны Хөх хотын дарга нар хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарт хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг, Хушаат сум дахь төмсний үр үржүүлгийн “Элит үр” ХХК-ий захирал С.Нямжав, ӨМӨЗО-ны Шү юань кан биологи технологийн компаний ерөнхий захирал Ши Юй-тэй, Сүхбаатар сум дахь сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн “Сэлэнгэ шим”ХХК-ий захирал Д.Мөнхцэцэг ӨМӨЗО-ны Шэнь мү гао кэ хөдөө аж ахуйн ерөнхий захирал Жан Жаван-тай хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурж хамтран ажиллаж, туршлага солилцохоор боллоо.

“Хууль бусаар болон бичил уурхайгаар алт олборлож буй иргэд, аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийх тухай” Аймгийн Засаг даргын 2019 оны А/270 тоот захирамжаар байгуулагдсан хууль хяналтын байгууллагуудын хамтарсан ажлын хэсгийн шалгалтыг Ерөө сумын Бугант тосгоны нутаг дэвсгэрт хийлээ. Хяналт шалгалтаар Бугант тосгоны Дунд өлөнт гэх газарт ажиллаж байсан “Улзгол” ХХК-ий уурхайн олборлолтын үйл ажиллагааг зогсоож нөхөн сэргээлтийг хийлгэх ажлыг гүйцэтгүүлж байна. Мөн хяналт шалгалт хийх явцад зохих зөвшөөрөлгүйгээр бичил уурхайгаар хууль бусаар алт олборлох зөрчилд ашигласан техник хэрэгслээ нуух, далдлах, эзгүй хаяж хяналт шалгалтаас зайлсхийж зугтах асуудлууд гарсан бөгөөд эзэн холбогдогчийг илрүүлэх, тогтоох, холбогдох хууль тогтоомжийн дагуу зөрчлийг шалган шийдвэрлэх ажлууд үргэлжлэн хийгдэж байна.

Онцгой байдлын газрын ажил үйлчилгээний талаар

тухай” удирдамж, аймгийн Засаг даргын 2019 оны “Ундны усны чанар, аюулгүй байдлыг хангуулж ажиллах тухай” А/63 тоот захирамжийн дагуу Сүхбаатар сумын төвлөрсөн ус хангамжийн системийг хариуцагч “Урсгал-Ус” ХХК-ий харьяа ундны усны эх үүсвэр болон зөөврийн-13, шугамын-10, гүний-1 худгийн ундны уснаас, цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир ус нь хүрээлэн буй орчинд нийлүүлэх стандартын шаардлага хангаж буй эсэх, цэвэрлэсэн бохир усыг нийлүүлж буй газрын хөрснөөс гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян агуулагдаж буй эсэхэд хяналт тавих зорилгоор дээж авч, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамрууллаа.

Тайлант сард зөрчлийн 4 хэргийг нээж, хуулийн хугацаанд нь аймгийн Прокурорын газрын хяналт дор шийдвэрлэж, нийт 13 аж ахуйн нэгжийн 42 дээжинд 272 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн бөгөөд 5 аж ахуйн нэгжийн 26 дээж 33 үзүүлэлтээр буюу шинжилсэн дээжийн 61,9 хувь нь эерэг гарлаа.

Мөн газрын цахим хуудсаар дамжуулан 22 удаагийн зөвлөмж сэрэмжлүүлэг, мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэн ажиллалаа.

Стандартчлал, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны талаар

Тайлант сард Алтанбулаг, Сайхан, Сүхбаатар сум, Бугант тосгоны нийт 14 аж ахуйн нэгж, иргэний 16 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, стандартын шаардлагыг 80%-иас дээш хангасан 10 аж ахуйн нэгж, иргэний 10 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгосон. Мөн шинээр тохирлын гэрчилгээ авах хүсэлтэй 2 хүнсний дэлгүүр, 1 гоо сайхны цэгт тохирлын үнэлгээ хийж, холбогдох зөвлөмжийг өгч ажиллалаа.

Бүтээгдэхүүн баталгаажуулалтын чиглэлээр Бугант тосгоны иргэн Б.Нямдэмбэрэлийн “Бугант хүнс” цехийн үйл ажиллагаанд дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт хийж, аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн Сорилтын лабораторит шинжлүүлсэн сорилтын дүнг үндэслэн тус цехийн үйлдвэрлэж орон нутгийн зах зээлд борлуулж буй талх, хэрчсэн гуриланд тохирлын гэрчилгээ олгосон. Мөн стандартын салбар сангаас 3 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 3 нэрийн 3 стандартаар хангаж, зөвлөгөө өгсөн. Эзлэхүүн хэмжлийн төрлөөр мөн Ерөө сум, Бугант тосгонд дуудлагаар ажиллаж, 3 шатахуун түгээх станцын 5 шингэн хэмжигчийг, механик хэмжлийн төрлөөр Сүхбаатар сум, Бугант тосгоны худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд ашиглаж буй 18 ш жин,э мийн сангийн 1 электрон жин, 3 туухайг, цахилгааны хэмжлийн төрлөөр Сүхбаатар сумын айл өрх, аж ахуй нэгж, төр төсвийн байгууллагын 21 ш 1 фазын цахилгаан тоолуурыг, дулаан, даралтын хэмжлийн төрлөөр 1 цусны даралтын аппаратыг тус тус баталгаажуулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

2018 оны ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн аудитын мөрөөр хийх ажлын төлөвлөгөөг гарган холбогдох газруудад хүргүүлэн хэрэгжүүлэх талаар чиглэл өгсөн бөгөөд нэгтгэсэн тайлангаар хязгаарлалттай үнэлгээ авсан 7 төсөвт байгууллагын удирдлагуудад сахилгын арга хэмжээ авлаа.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн дансанд байршуулж, санхүү, бүртгэл эдийн засгийн Улсын зөвлөгөөнийг Сайхан суманд сумдын төрийн сангийн мэргэжилтэн, татварын байцаагчдыг хамруулан зохион байгуулсан.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	1. Орон нутгийн төсвийн нийт орлого	48.146.767.2	46.581.176.0	96.7
1.1	Орон нутгийн төсвийн орлого	13.636.746.9	12.196.692.2	89.4
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	10.581.297.6	9.038.949.6	85.4

	Сумдын төсвийн орлого	3.055.449.3	3.157.742.6	103.3
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	3.348.428.7	3.348.428.7	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	27.764.943.9	27.763.325.4	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	3.264.821.8	3.140.903.8	96.2
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/			
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	131.825.9	131.825.9	100.0
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		60.372.211.7	50.975.862.9	84.4
Орон нутгийн төсвийн нийт зарлага		29.092.257.2	22.286.300.6	76.6
Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага		11.856.170.9	8.286.859.0	69.9
Сумдын орон нутгийн хөгжлийн сан		1.535.347.7	687.541.5	44.8
Сумдын сум хөгжүүлэх сан				
Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага		17.236.086.3	13.999.441.6	81.2
Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт		600.000.0	317.632.4	52.9
Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт		549.000.0		
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан		1.784.135.4	1.125.617.4	63.1
Халамжийн сан		298.491.0	187.235.0	62.7
Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага		5.523.500.3	3.891.472.9	70.5
Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө		217.800.0	214.324.2	98.4
Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		30.766.185.1	28.190.768.6	91.6
Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		513.769.4	498.793.7	97.1
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		36.110.474.5	36.110.474.5	100.0
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	8.263.159.6	8.263.159.6	100.0
Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		1.619.337.2	1.619.337.2	100.0
Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд		83.989.5	83.989.5	100.0
Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд				
Хөрөнгө оруулалтын зардалд		1.535.347.7	1.535.347.7	100.0
Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		2.078.286.0	1.419.768.0	68.3
Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд		1.784.135.4	1.125.617.4	63.1
Усны татаас		21.650.6	21.650.6	100.0
Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд		272.500.0	272.500.0	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	27.318.271.0	27.318.271.0	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	445.054.4	445.054.4	100.0
Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/		27.763.325.4	27.763.325.4	100.0
- Ерөнхий боловсролын сургууль		15.156.186.5	15.156.186.5	100.0
- Хүүхдийн цэцэрлэг		8.091.506.9	8.091.506.9	100.0
- Эрүүл мэндийн байгууллага		3.968.819.2	3.968.819.2	100.0
- Газрын кадастрын байгууллага		271.745.0	271.745.0	100.0
- Хүүхдийн байгууллага		275.067.8	275.067.8	100.0
4. Тусгай сангуудын зарлага				
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1.385.440.6	89.703.9	6.5

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2018 07- сар	2019 07- сар	2019- 07 2018-07 /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА			
1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
Гурил /савласан, кг/	1 100	1 100	100.0
Талх /орон нутгийн, ш/	1 100	1 200	109.1
Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
Будаа /кг/	2 400	2 400	100.0
Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
Хонины мах /кг/	6 500	8 000	123.1
Үхрийн мах /кг/	7 500	9 000	120.0
Адууны мах /кг/	5 800	7 500	129.3
Ямааны мах /кг/	5500	7 000	127.3
Дотор мах, цувдай /цусгүй/	3500	4 000	114.3
Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
Сүү /задгай, л/	800	1 000	125.0
Сүү / савласан, л/	2 600	2 700	103.8
Тараг /задгай, л/	1 000	1 300	130.0
Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	15 000	115.4
Айраг /л/	3 500	3 500	100.0
Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
Өндөг /ш/	350	350	100.0
4 БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
Өөхөн тос /кг/	2 000	2 000	100.0
Шар тос /кг/	13 000	13 000	100.0
Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5 ХҮНСНИЙ НОГОО			
Төмс /кг/	1 200	1 000	83.3
Лууван /кг/	1200	1 200	250.0
Манжин /кг/	1500	1200	80.0
Байцаа /кг/	1500	1500	100.0
Сонгино /кг/	1500	1500	100.0
Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	121.7
Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 300	100.0
7 ШАТАХУУН			
Бензин А - 80	1 645	1 750	106.4
Бензин А - 92	1 795	1 850	103.1
Дизелийн түлш	2 105	2 370	112.6

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2019 оны 07 дугаар сард гэмт хэргийн шинжтэй 718 гомдол ирж нийт 445 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар өссөн байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 8 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 166 бичиж, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 75, лавлагаа 13 олгож үйлчилсэн. Мөн иргэний бүртгэлийн чиглэлээр төрсний бүртгэлд 189, гэрлэлтийн бүртгэл 26, гэрлэлт цуцалсны бүртгэл 9, эцэг тогтоолт 66, овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 9, нас баралт 59 бүртгэгдэж, гадаад паспорт олголт 72, ОХУ-ын хавсралт 1502 иргэнд олгож, аймаг

хотоос бүр мөсөн шилжин ирсэн 186, хот доторх шилжилт хөдөлгөөн 197 тус тус хийгдлээ.

“Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийн бэлтгэл ажлын хүрээнд “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, хариуцсан ажилтан болон төрийн албан хаагчдад зориулсан видео хичээл” болон Улсын үзлэгийн дүгнэх үзүүлэлт, аргачлалын дагуу 4 цуврал гарын авлагыг бэлтгэн газар, хэлтэс, албад болон сумдын Засаг даргын Тамгын газруудад хүргүүлж, улсын үзлэгт бэлтгэсэн ажлын тайлан мэдээг газар, хэлтэс, албад болон сумдын Засаг даргын Тамгын газраас авч үр дүнг тооцон ажиллаж байна.

Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “Төрийн байгууллагын архивын хөгжил, төлөвшилт” танилцуулга, үзүүлэх сургалтад тасгийн дарга, сан хөмрөгийн эрхлэгч нар оролцсон.

Аймгийн төр, төсвийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 23 газрын хэвлэмэл хуудасны эх загварыг хянаж, цахимжуулалтын 8-р сарын мэдээг гаргаж Архивын ерөнхий газарт тус тус хүргүүлсэн.

Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Баруунхараагийн Гурил тэжээлийн үйлдвэр, Ерөөгийн мод бэлтгэлийн аж ахуйн хөмрөгийн 2-р дансны 30 хн-д ЭШТБ ажлыг хийж 3541 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэсэн. Мөн Баруунхараагийн Гурил тэжээлийн үйлдвэр, Ерөөгийн мод бэлтгэлийн аж ахуйн хөмрөгийн 2-р дансны 28-хн-ний 3389 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 3012, хүний нэр 21447, газарзүй нэр 1543, байгууллагын нэр 1325-г шивжсэн. Мөн хөмрөгийн 27 хн-ийн 3264 хуудас баримтыг мастер хувьтай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Ард иргэд албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын баримтаас цахим хэлбэрээр-145, мастер хувиас-57 цаасан суурьтай баримтаас - 32 нийт 234 лавлагаа гарган үйлчилсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар батлагдсан хичээлийн жилийн бүтэц, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, эцэг эх, асран хамгаалагчтай байгуулах гэрээний загвар, сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний талаарх мэдээллийг сургууль, цэцэрлэгүүдэд цахимаар хүргүүлсэн.

2019-2020 оны хичээлийн шинэ жилийн багш нарын бага хурлыг зохион байгуулж, нийт 450 гаруй багш, удирдах ажилтан хамрагдалаа. Мөн 8-р сарын 05-10-ны өдрүүдэд “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” сэдэвт сургалтад сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтэн, бага боловсролын мэргэжилтэн хамрагдаж үндэсний сургагч багшаар бэлтгэгдсэн.

Увс аймагт зохион байгуулагдсан "Дотуур байран дахь хичээлээс гадуурх үйл ажиллагаа, эцэг эхийн оролцоо" сургалтад БСУГ-ын мэргэжилтэн, сумдын сургуулийн нийгмийн ажилтан оролцож, туршлага судаллаа.

“Сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтыг 2019 оны 8-р сарын 15-18-ны өдрүүдэд БСШУСЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх инстут, Боловсролын хүрээлэнтэй хамтран зохион байгуулж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтан, МСҮТ-ийн ерөнхий эрдмийн нийт 1403 багш нар хамрагдаж 84.9 хувь хамрагдсан.

Энэ хичээлийн жилд хэрэглэгдэх сурах бичиг сургуулиудад түгээх ажлыг сургууль бүрийн хүүхдийн тоонд үндэслэн хуваарийг хийж, хуваарийн дагуу олгож байна.

Монгол Улсын Их хурлын гишүүн Н.Оюундарийн нэрэмжит аймгийн төвийн бүсийн иргэдийн спортын II наадмыг Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Жавхлант, Хүдэр сум, Дулаанхаан тосгоны иргэдийг хамруулан 8-р сарын 13-14-ний өдрүүдэд явган аялал, ажлын байрны дасгал, хөл бөмбөг, волейбол, сагсан бөмбөг, шатар,

ширээний теннис, олс таталт, шагайн наадгай гэсэн 10 төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 800 гаруй тамирчид оролцлоо.

2.Эрүүл мэндийн чиглэлээр

“Жишиг эмийн сан”-ийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвд хяналт үнэлгээ хийлээ. Үнэлгээгээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн сан “Сайн”, Алтанбулаг сумын эрүүл мэндийн төв “Маш сайн” үнэлэгдлээ.

“Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, хүн амын мэдээллийн цахим санг бүрдүүлэх цогц үзлэг оношилгоо”-г Хушаат сумын иргэдийн дунд 7-р сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгуулж 740 иргэнд дотор, зүрх судас, дотоод шүүрэл, эмэгтэйчүүд, мэдрэл, эрэгтэйчүүд, сэтгэц, шүд, охид, хөвгүүд, нүдний гэх мэт нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг хийж зөөврийн Эхо, дижитал рентген аппаратаар цээжний хөндийн эмгэг болон дотор, эмэгтэйчүүдийн өвчнийг илрүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн.

2019 оны 08 сарын 8-11-ны өдрүүдэд Хүдэр суманд үйл ажиллагаа явуулдаг “Дархан Төмөртэй уурхай”, Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг “Болд төмөр Ерөө гол” ХХК-ны ажиллагсдын дунд “БЗДХ-Сүрьеэ” өвчний эрт илрүүлэг үзлэг оношилгоог зохион байгуулж 1120 хүнийг хамруулсан. Үүнээс 20 хүн рентген шинжилгээнд өөрчлөлттэй бөгөөд цэрний шинжилгээ авч 3 шинэ тохиолдлыг илрүүлэн эмчилж байна.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2019 оны 07-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 598 байсан бол 162 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 112 ажлын байранд 96 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 27 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 637 болсон байна.

Монгол улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хооронд байгуулсан “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу ажилтан илгээх болон хүлээн авах тухай “ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ” болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 1/940 албан тоотыг үндэслэн Солонгос хэлний Түвшин тогтоох шалгалтын бүртгэлийг 2019 оны 8-р сарын 6-7-нд зохион байгуулж, 11 эмэгтэй, 29 эрэгтэй болон нийт 40 иргэний бүртгэлийг хийсэн.

Нийгмийн халамжийн сангаас 8 сарын байдлаар 38,725 иргэнд 9,968,882.2 мянган төгрөгийг олгоод байна.

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2475 иргэнд 3,206,033.3 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1689 иргэнд 887,877.8 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1644 иргэнд 536,558.6 мянган төгрөг
- Онцгой тохиолдлын тэтгэмж 47 иргэнд 56,400.0 мянган төгрөг
- Ахмад настны тусламж, хөнгөлөлт 3468 иргэнд 327,984.5 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 445 иргэнд 117,655.4 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 2394 эхэд 289,770.8 мянган төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 70 иргэнд 54,594.9 мянган төгрөг
- Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 8838 иргэнд 1,151,600.0 мянган төгрөг
- Насны хишиг 5022 иргэнд 720,240.0 мянган төгрөг
- Цалинтай ээж хөтөлбөр 6388 иргэнд 2,000,185.3 мянган төгрөг
- Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжинд 220 иргэнд 129,638.7 мянган төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 1050 өрхөд 6025 иргэнд 490,342.9 мянган төгрөгийг олгоод байна.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 3 дуудлага ирж хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлсэн. дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлөөр ангилбал:

-Үл хайхрах хүчирхийлэл – 1

-Бэлгийн хүчирхийлэл – 2

Бэлгийн хүчирхийллийн хохирогч Э-г Алтанбулаг сумын түр хамгаалах байранд байрлуулж, суурь үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн.

Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд “Хайр дүүрэн хүүхэд” зөв үйлсийн аян урлагийн тоглолтыг зохион байгуулж 450 гаруй хүүхэд хамрагдсан. “Хүчээ нэгтгэе” хэлэлцүүлэгийг зохион байгуулж 20 хүн хамрандсан.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

Нийгмийн даатгалын хэлтэс нь 2019 оны 8-р сарын байдлаар 19,34 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 08 дугаар сарын 29-ны байдлаар өссөн дүнгээр 24,29 тэр бум төгрөгний орлого төвлөрүүлж 125.61 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16769 тэтгэвэр авагчдад 40775886 сая төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 4355 хүнд 1821861 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 276 хүнд 688025 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 292 хүнд 457865 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 2019 оны 08 сард нийт 4 удаа хуралдаж 276 хүнээс, 13 хүнийг цуцалж, 52 хүн шинээр тогтоолгосон, 211 хүн актаа сунгуулсан. явуулын хурлыг Сайхан, Баянгол, Мандал сумдуудад 1 удаа хуралдуулж нийт 247 хүний асуудал хэлэлцэж, 139 иргэний ХЧА-ын хувь хугацааг сунгаж 8 иргэний ХЧА-хувийг цуцалсан. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг 08 сард 770 иргэд, даатгуулагчдад гарган түргэн шуурхай үйлчиллээ.

“Даатгуулагч танд урьдчилан зөвлөө-тусалъя” сэдэвт тэтгэврийн аянг зохион байгуулж тэтгэвэр авагчдын тэтгэврийг хуульд заасан хугацаанд нь тогтоох зорилгоор 17 сумын Засаг дарга, 3 тосгоны захирагч нарт ажил хөдөлмөр эрхлээгүй тэтгэвэр тогтоолгох иргэдийн судалгааг гаргаж ирүүлэх тухай албан тоотыг хүргүүлж эхний хагас жилийн байдлаар 512 иргэний судалгааг гаргаж 312 иргэнд зөвлөмж олгон зөрчлийг арилгуулж 294 өндөр насны тэтгэвэр тогтоогоод байна.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Ургамал газар тариалангийн хүрээлэн, “Элит үр” ХХК-тай хамтран Хушаат суманд сургалт хийлээ. Сургалтаар УГТХ-ээс “Нэг наст буурцагт ургамлын үржүүлэг, тариалах технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэл”-ийн талаар мэдээлэл хийж, шар буурцагны бүтээгдэхүүнээр хийсэн хүнсний бүтээгдэхүүнийг танилцуулж, буурцагт ургамлын талбайн өдөрлөгийг зохион байгууллаа. Сургалтад Хушаат, Сант, Орхон, Баянгол, Зүүнбүрэн сумдын 50 гаруй тариаланчид оролцлоо.

Сортын хянан баталгаа хийлгэх 30 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлсэний дагуу Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Сэлэнгэ салбарын менежер, Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн мэргэжилтэнтэй хамтран 15 аж ахуйн нэгжийн талбайд хянан баталгаа хийгээд байна.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Баянгол, Баянзүрх дүүргүүдэд Сэлэнгэ аймгийн “Шинэ ургацын төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаа”-г зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд “Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн сонгон шалгаруулалт”-ыг хийж, эх үүсвэрт багтаан тэргүүн ээлжинд санхүүжүүлэх 4 аж ахуйн нэгж, 15 иргэний 1,0 тэрбум төгрөгийн төслийн жагсаалтыг гарган банкуудад хүргүүлээд байна.

2019 онд 726820 толгой эх мал төллөхөөс 08 дугаар сарын 25-ны байдлаар 602114 эх мал төллөж мал төллөлт 83 хувьтай, төл бойжилт 99 хувьтай байна.Төлийн зүй бус хорогдол 5169, том малын зүй бус хорогдол 3456 байна. Бойжиж буй төл малыг төрлөөр нь авч үзвэл ботго 129, унага 23584, тугал 72075, хурга 292535, ишиг 209430 толгой байна.

Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага, Мал эмнэлгийн Ерөнхий газар, Японы Обихирогийн хөдөө аж ахуй мал эмнэлгийн сургуультай хамтран Хустайн байгалийн цогцолбор газарт зохион байгуулсан “Мал амьтны трипаносомозын Олон улсын IV Их хурал”-д сумдын мал эмнэлгийн тасгийн малын их эмч нарыг хамруулсан. Мөн малын “Халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ” сэдэвт дадлага ажлын нэгдсэн үзүүлэх сургуулийг Түшиг суманд зохион байгуулж, аймгийн Мал эмнэлгийн газрын 11, сумдын мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч, тархвар зүйч 19, МЭҮН-ийн 30 нийт 60 гаруй малын эмч мэргэжилтнүүд хамрагдан онолын мэдлэгээ дээшлүүлэн дадлага эзэмшлээ.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, дагалдан гарсан дүрэм журам болон Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 02 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 01 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын 2019 оын А/154 тоот захирамжийн хэрэгжилтийг Жавхлант, Ерөө, Хүдэр, Хушаат, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумдын мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хийж, бод, бог малын шимэгчтэх өвчнийг эмчлэх урьдчилан сэргийлэх мал угаалгын ажлын явц, үр дүнг газар дээр нь үзэж үнэлж дүгнэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан ажиллаа.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэн Ч.Ганбаяр Хэрх 4-р багийн нутаг дэвсгэрт малын гоц халдварт “Бог малын мялзан” өвчний эрсдэл бүхий Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ишгэн хөндий гэдэг газарт отор нүүдэл хийж нутаглаж байгаад 2019 оны 07дугаар сарын 09 нд Мандал сумын хэрх багт үхэр 46, адуу 48, бог мал 650, нийт 744 тооны мал тууж ирэн нутаглаж байгааг илрүүлэн нийт 50 богоос дээж авч аймгийн мал эмнэлэг болон төв лаборторт явуулж Хэрх 4-р багийн 15 өрх айлийн 1150 толгой малыг 14 хоногын хугацаатай хязргаалалт дэглэм тогтоож ажилллаа.

Зүүнбүрэн сумаас ирсэн 12 эмгэгт эдийн дээжинд нян судлалын шинжилгээ, Алтанбулаг, Цагааннуур, Сүхбаатар, Орхон Сүхбаатар, Түшиг, Жавхлант, Шаамар, сумдаас ирсэн үнээ - 586, бух-156, хуц-631, ухна-602, нийт 1975 мал, амьтанд бруцеллөз, 586 үнээнд лейкоз, сүрьеэ, бабезиоз өвчний шинжилгээ, хийж халдваргүй болохыг тогтоож, Зүүнбүрэн сумын 152 адууны цусны дээжинд Адууны халдварт цус багадах өвчин, ям, хачигт халуурал, нийлүүлэгийн өвчний шинжилгээ хийж адууны халдварт цус багадах өвчнөөр эерэг 3, нийлүүлгийн өвчнөөр эерэг -1, хачигт халууралаар эерэг 90 тус тус эерэг урвал үзүүлж, ям өвчнөөр эрүүл болохыг оношлож УМЭАЦТ-т баталгаажуулан зохих газарт хариуг хүргүүлж, Сүхбаатар сумын хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 14360 кг үхрийн махны 97 дээж, 2135 кг хонины махны 89 дээж, 80 кг ямааны махны 4 дээж, 95 кг гахайн махны 1 дээж, 640 кг адууны махны 4 дээж, 70 л сүүний 4 дээж, 1200 л тарагны 3 дээж, 60 ш өндөгний 1 дээжинд магадлан шинжилгээ хийж баталгаажуулан ариун цэврийн гэрчилгээ олгосон.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

Аймгийн Засаг даргын 6 удаагийн захирамжаар нийт 11 иргэн, 2 төрийн байгууллагад шинээр газар эзэмшүүлж, 5 иргэний газар эзэмших эрхийг

баталгаажуулж хуулийн хугацаанд өргөдлийг шийдвэрлэв. Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар 25 иргэн, 2 аж ахуйн нэгж, 2 төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээнд Э дугаар авах хүсэлтийг дундын мэдээллийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн хэлтэст илгээв. 21 иргэн, 1 аж ахуйн нэгж, 2 төрийн байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулан газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулсан.

Эрх бүхий байгууллагаас шаардсан шаардлагыг заасан хугацаанд биелүүлээгүй зөрчил гаргасан “Алтан тариа” ХХК-ий зөвшөөрөлгүй барьсан хашааг албадан чөлөөлөх тухай аймгийн Засаг даргын 2018 оны А/356 тоот захирамжийн дагуу газар албадан чөлөөлөх ажиллагааг Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтарч зохион байгуулж, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийг зөрчсөн 5 иргэнд газар чөлөөлөх албан мэдэгдэл хүлээлгэн өгсөнөөс 3 иргэн зөрчил арилган 2 иргэний дараагийн шатны байгууллагад шилжүүлэв.

Байгалийн гэнэтийн гамшгаас үүдэн гарсан зам талбай болон тариалангийн талбайд гарсан эвдрэл, мөндөрт цохиулсан улаан буудай тариалсан талбайн хэмжээ зэргийг газар дээр нь хэмжилт хийж, сумдын үр тарианы зориулалтаар газар эзэмшдэг иргэн, аж ахуйн нэгжүүдийн газар эзэмших гэрээг дүгнэх ажлыг эхлүүлээд байна.

Тайлант сард 2019 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн дараах зураг төсвийг хянаж баталгаажуулсан. Үүнд:

- Сайханы хөтөл аялал жуулчлал, амралт, зугаалгын бүсийн скиз зураг
- Сайхан сум, Номгон тосгонд барилгдах халуун усны барилгын зураг төсөл
- Сүхбаатар сум “Юнигаз” ХХК –ний модуль автомашин хийгээр цэнэглэх станцын зураг төсөл.
- Шаамар сум, Дулаанхаан тосгон “Төгс эрдэнэ төгөлдөр” ХХК –ний аялал жуулчлалын газрын гадна цахилгааны ажлын зураг.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн төсөл арга хэмжээнд архитектур төлөвлөлтийн даалгавар гаргаж ажиллалаа. Үүнд:

- Орхон сум Бэлэндалай төмөр замын 24 айлын орон сууц.
- Алтанбулаг сум аймгийн музейн засварын ажил.
- Шаамар сум, Дулаанхаан тосгон “Төгс эрдэнэ төгөлдөр” ХХК –ний аялал жуулчлалын газар.
- Сүхбаатар сум “Юнигаз” ХХК –ний модуль автомашин хийгээр цэнэглэх станц
- Мандал сум Түнхэл тосгон 75 ортой дотуур байр.
- Мандал сум иргэн Д.Даваадоржийн үйлчилгээтэй орон сууц.
- Сүхбаатар сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга.

Мөн Баруунбүрэн сумыг Магнай уул, Цагаан толгойд баригдсан “Мобиком” ХХК-ий үүрэн холбооны сайтын гадна цахилгаан хангамжийн ажил, Сүхбаатар сумын 1-р цэцэрлэгийн барилгын гадна фасад, Цагааннуур сумын цэцэрлэгийн гадна фасад, Түшиг сумын ЗДТГазрын гадна фасад, Цагааннуур сумын спорт заалны шалны засварын ажлууд болон Түшиг суманд аймгийн төсвийн хөрөнгөөр Соёлын төвийн барилгын засварын ажлыг хүлээн авах улсын комисс ажилласан.

Долоо. Байгаль орчны чиглэлээр

Мандал суманд ой зохион байгууллага хийж буй “Аглаг ой” ХХК, Баруунбүрэн суманд “Гранд форест” ХХК, “Залуу төгөл” ХХК, Түшиг суманд “Хатан форест” ХХК зэрэг аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг газар дээр нь шалгаж, БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газар, “ОСХТ” УӨУҮГ-тай хамтран “Ой зохион байгуулалтын ажлын арга зүй, стандарт, норм, нормативыг шинэчлэх асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр “ой зохион байгуулалтын ажлын арга зүй, ойн менежментийн асуудал, ОЗБ-ын ажлын чанар, орон нутагт тулгарч байгаа бэрхшээл, ой зохион байгуулалтын шинэчилсэн арга зүй, ойн тооллого, ой зохион байгуулалтын ажилд тавигдах ерөнхий шаардлага, 1 га-гын нормативийг шинэчлэх” зэрэг асуудлаар мэдээлэл хийх, хэлэлцүүлээ.

Аймгийн хэмжээнд ойжуулалт, мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх бүхий 50 гаруй байгууллагыг хамруулан “Ойжуулалт-Ойн зурвас” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр “ойжуулалтын ажлын өнөөгийн байдал, ойн зурвас байгуулахад анхаарах зүйлс, цаашид авах арга хэмжээ, мод үржүүлгийн газар, ойн аж ахуйн арга хэмжээний 1 га-гийн норм, нормативыг шинэчлэх талаар болон үр боргоцой бэлтгэхэд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлж буй нөлөөлөл” зэрэг сэдвүүдээр мэдээлэл хийж, хэлэлцүүлж, санал солилцлоо.

Найм.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойн хүрээнд Монгол Улс, Оросын Холбооны Улсын зочид, оюутан залуусын хамтарсан “Дайчин нөхөрлөлийн замаар” тойрон аялалын баг энэ сарын 21-ний өдөр “Зөвлөлийн дайчдын хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүллээ.

Ургац хураалтын бэлтгэл ажлыг хангах үүднээс зам засварын зургийг авч, холбогдох газарт хүргүүлж, Цөх 3-р багийн нутаг дэвсгэр Хярааны төмөр гүүрнээс Баянцагаан өвөлжөөний урд талын 1,5 км шороон замыг засварласан.

Тайлант сард сумын эрүүл мэндийн төвөөс хүүхдийг эхийн сүүгээр хооллох бодлогыг дэмжих Дэлхийн 7 хоногийг тэмдэглэн өнгөрүүлж, иргэдэд сурталчлах арга хэмжээг хийж, “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхмыг хэрэгжүүлэх заавар, “Нялх, балчир насны хүүхдийн хүнсний тухай хуулийг сургалталчиллаа.

Баруунбүрэн сум:

Сумын хэмжээнд урьдчилсан ургац тогтоолтыг 8-р сарын 15,16-ны өдрүүдэд зохион байгуулсан. Урьдчилсан дүнгээр 9364 га талбайн үр тарианы 460 га талбай нь ганд, 310 га талбай нь мөндөрт цохиулсны улмаас 840 га талбай нь тэжээлд шилжиж, 7754 га талбайгаас 8504 тонн буюу 11 цн хураан авахаар урьдчилсан дүн гараад байна. Тэжээлийн ургамал 190 га талбайгаас 40 га мөндөрт цохиулж, үлдсэн 150 га талбайгаас 300 тонн, рапс 1834 га талбайгаас 953 га талбай нь хураах боломжгүй болж, үлдсэн 881 га талбайгаас 428 тонн, төмс 80 га талбайгаас 640 тонн, хүнсний ногоо 76 га талбайгаас 570 тонн ургац тус тус хураан авахаар байна.

Сортын хянан баталгааг “Бүрэн оргил од”, “Ивэн түрүү” ХХК-ууд 758 га талбайд хийлгэсэн.

Бог малын ангилалтыг хийж, нийт 5000 хонь, 1000 ямаа хамрагдаж, холбогдох материалыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлээд байна.

Том малын хорогдлын, төл бойжилтын мэдээг гаргахад сумын дүнгээр том малын хорогдол нийт 717 байгаагаас адуу 85, үхэр 120, хонь 225, ямаа 287 толгой байна. Төл бойжилт нийт 41209 хээлтэгч төллөснөөс ингэ 3, гүү 1495, үнээ 2907, эм хонь 21804, эм ямаа 15000, төлийн хорогдол нийт 3102, унага 110, тугал 200, хурга 1332, ишиг 1460, бойжиж буй төл 38107 үүний унага 1385, тугал 2707, хурга 20472, ишиг 13540 ботго 3 толгой тус тус бойжиж байна.

2019 оны 8-р сарын 2-нд “Шинэ Орос хийц” ХХК Бургалтайн аманд үндсэн ашиглалтын огтлолтоор 12 га талбайд тусгаарлалт, 8-р сарын 3-нд Сайхан сумын

“Хэт жолоо” ХХК мэргэжлийн байгууллага цэвэрлэгээний огтлолтоор 31 га талбайд тусгаарлалтын ажлыг хийлээ.

Орхон бүсийн сум дундын ойн ангийн дарга Ү.Баян-Эрдэнэ, 2-р багийн байгаль хамгаалагч М.Хүдэр нар Зүүвч,Хүж,Хавчуу Сэндэн зэрэг газруудад эргүүл шалгалт явж түлшний мод ачсан 6 тээврийн хэрэгсэл шалгахад бүгд эрхийн бичигтэй байсан. Мөн Сайхан сумын Хэт жолоо мэргэжлийн байгууллагын мод бэлтгэж байгаа талбайг үзэж шалгалаа.

Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нар Ивэн 1-р багт 8-р сарын 16-19 хүртэл ажиллаж, нийт 100 хүнд эмнэлгийн ахнан шатны тусламж үйлчилгээг үзүүлж, осол гэмтэлд өртсөн 5 хүн, аянгнад цохиулсан 5 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажилласан.

Баруунбүрэн сумын харъяат, “Хилчин” спорт хорооны үндэсний бөхийн дасгалжуулагч, “Таванхан” дэвжээний бөх, Монгол улсын өсөх идэр начин, чөлөөт бөхийн олон улсын хэмжээний мастер, дэд хурандаа Наранцэцэгийн Бүрэнбаатарын нэрэмжит гар бөмбөгийн тэмцээн, үдшийн хүлээн авалт, гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй эмэгтэй нийлсэн нийт 29 баг оролцлоо.

Мандал сум:

БНСУ-ын Иксан аймгийн нарийн мэргэжлийн эмч нар 8 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд тус суманд ажиллаж үзлэг оношлогоо хийлээ. Үзлэгт сумын нийт 893 хүн хамрагдаж давхардсан тоогоор 1514 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлснээс гадна эмийн сангаар үнэ төлбөргүй үйлчилж шаардлагатай мэс заслуудыг хийлээ.

Ахмад настны тухай, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах тухай хуулийн дагуу Улаанбаатар хотын “Лосел” ХХК шүдний эмнэлэгтэй хамтран хиймэл шүдийг хөнгөлөлттэй үнээр хийх ажлыг зохион байгуулсан бөгөөд, нийт 87 иргэн 9,8 сая төгрөгийн хиймэл шүд хийлгэлээ.

1981-1984 онд Хэрх сангийн аж ахуйн илгээлтийн эздээс зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдаж буй 2, 6-р багийн 3 өрхөд нийт 150,000 төгрөгийн хоол хүнсний бүтээгдэхүүний тусламж үзүүлж, шинээр төрсөн 35 хүүхдийг бүртгэж, өрхийн мэдээллийн санд бүртгэсэн.

Малын халдварт гоц халдварт өвчний тандалт, хяналтыг тогтмолжуулж, эрсдэл бүхий бүс нутгийн мал сүргийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулж үр дүнг сайжруулан өвчнөөр тайван нөхцлийг хадгалах зорилгоор Мал сүргийг гоц халдварт, халдварт өвчнөөс сэргийлэх тарилга, паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх угаалганд бог, бод 36324 толгой, туулгалт 499 нохой бусад төрлийн эмчилгээ, ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2011 оны 221 дүгээр тогтоолоор баталсан хонь, тэмээний ноос, арьс шир бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчдад мөнгөн урамшуулал олгох журмын хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 онд 3774 ширхэг арьс шир үндэсний үйлдвэрт нийлүүлж 56 малчин өрх 11 тонн ноос үндэсний үйлдвэрт нийлүүлж 15,7 сая төгрөгийн урамшуулалд хамрагдлаа.

Мод бэлтгэлийн т ажил дууссан 4 аж ахуйн нэгж, байгууллагын 41 га талбайн мод бэлтгэлийн ажил дуусч, цэвэрлэгээ хийсэн талбайг акт үйлдэж хүлээн авсан.

Мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг 7 аж ахуйн нэгж, байгууллага, 4 иргэнд 759 м3 хэрэглээний, 118 м3 түлээний буюу нийт 877 м3 мод бэлтгэх зөвшөөрөл олгож, 12 аж ахуйн нэгж, байгууллагын 1143.5 м3 хэрэглээний, 350 м3 түлээний, нийт 1493.5 м3 мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгож, мод бэлтгэлийн үйл ажиллагаанд байгаль хамгаалагч нар болон ойн ангиас долоо хоногт 2 удаа хяналт шалгалт хийж, доод агуулахын гүйцэтгэл гаргаж байна.

Сумын Засаг даргын Тамгын газрын барилгын гадна фасадыг орчин үеийн чанар, өнгө үзэмж сайтай метал хавтангаар шинэчилж, дээврийг бүрэн засварлаж ашиглалтанд орууллаа.

Улаанбаатар–Дархан чиглэлийн /А0401/ авто замын 130 км-ээс Мандал сум хүртэлх хуримтлуулах 30 км авто замын ажлын гүйцэтгэл 30 хувьтай, сумын төвийн

доторх 6,5 км зам барилгын ажлын гүйцэтгэл 25 хувьтай, Нэгдсэн эмнэлэгт цахилгаан шат суурилуулах ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

Түнхэл голын эрэг дагуу газар өмчилж авсан гэр хорооллын 40 айл өрх жил бүрийн 2-4 дүгээр сард Түнхэл гол гэсэх үеэр болон 7, 8 дугаар саруудад усархаг борооны үерт өртдөг эрсдэл, эмзэг байдлыг бууруулах зорилгоор Дэлхийн зөн Зүүнхараа ОНХХ, Бороо Гоулд ХХК нартай хамтран 1,4 км үерийн далан байгуулах ажлын гүйцэтгэл 50 хувьтай, Ширхэнцэгийн 2-р багт Төрийн үйлчилгээний 2-р байрны зүүн талд 2 ширхэг 5 давхар 30 айлынорон сууц барих ажлыг эхлүүлээд байна. Ажлын гүйцэтгэл 30 хувьтай, Минжийнхангайн 7-р багт Цагдаагийн албан хаагчдын 5 давхар 30 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэл 25 хувьтай байна.

Мөн Түнхэл тосгоны 10 ортой эрүүл мэндийн төвийн барилгын улаан шугамыг тавьж суурийн ажлыг эхлүүлж, Хэрх тосгонд ухаалаг худгийн систем суурилуулах зорилгоор хуучирсан худгийн барилгын дээвэр, хана, тааз, цонх, хаалгыг засварлах ажлууд хийгдэж байна.

Баянгол сум

Сумын Засаг даргын Тамгын газар, гал түймэр унтраах аврах 40 дүгээр ангитай хамтран сумын нэн эмзэг өрхүүдийн цахилгааны аюулгүй байдлыг шалгаж, зайлшгүй шинэчлэлт хийх талаар заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Баянгол сумын уяачдын холбооны 20 жилийн ой, аймгийн алдарт уяач Т.Төрмөнхийн цолны мялгаалга наадмыг 7-р сарын 25, 26-ны өдөр зохион байгуулж, 6 насны хурдан морины уралдаан, хүчит 32 бөхийн барилдаан боллоо. Мөн аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооноос зохион байгуулсан “Хамтдаа хөгжье” арга хэмжээнд 7 иргэнийг оролцуулсан.

Сумын соёлын төвөөс тайлант сард 5 удаагийн урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулж, 1166 иргэн хамрагдсан. Номын сангаас танхимаар 5, гэрээр 3 уншигчид 14 номоор үйлчилсэн.

Сумын эрүүл мэндийн төв тайлант сард амбулаторийн 389 үзлэг хийж, 23 иргэнийг онош тодруулахаар дээд шатны эмнэлэгт илгээж, 351 иргэн өдрийн эмчилгээг эмчийн заалтаар хийсэн.

Америкийн Нэгдсэн Улсын Номхон далайн командлалын агаарын нисэх хүчин, Монгол Улсын Зэвсэгт хүчин хамтран “Номхон далайн элч-2019” хамтын дадлага сургуулилтыг 7-р сарын 31-ээс 8-р сарын 1-ний өдрүүдэд сумын ЕБС-д зохион байгуулж, нарийн мэргэжлийн эмч нар /нүд, шүд, дотор, ЭХО, рентген, эмэгтэйчүүд, мэс засал, хүүхэд гэх мэт/ үзлэг оношлогоо хийж үйлчиллээ.

Сургуулийн дотуур байрны 20 өрөөний хуучин модон шалыг паркетлаж сурагчдын амьдрах орчныг сайжруулж, дотуур байрны болон сургуулийн гал тогооны гадна фасадны ажлыг хийгээд байна.

Сумын цэцэрлэг нь түүхт 50 жилийн ойгоо угтаж, эцэг эхийн тусламж дэмжлэгээр гадна талбайн тохижилт, туршилтын талбайг бий болгох ажлуудыг хийлээ. Мөн цэцэрлэгийн гадна, дотор талын засвар, явган хүний зам тавих ажлуудыг хийгээд байна.

2019 онд тариалсан талбайн ургацын урьдчилсан баланс гаргах ажлыг хэсгийг томилон ажиллуулж, сумын дунджаар улаан буудай 10,8 цн, рапс 4 цн, төмс 140 цн, хүнсний ногоо 160 цн авахаар тогтоогдсон.

Мал эмнэлэг, үржлийн нэгжүүд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт вакцинуудыг хийж, 96100 толгой мал хамруулахаас 88900 толгой малыг хамруулж, 92,5 хувьтай байна. Мөн шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд мал угаалгын ажилд төлөвлөгөөт 114000 толгой малд хамруулахаас 122638 толгой малыг угаалгад хамруулсан.

Сант сум

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын 2019 оны 7 тоот албан даалгаврын дагуу сумын Засаг даргын 2019

оны А/94 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдан төв суурин, хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Бэлтгэл ажлын хүрээнд сумын 260 иргэнд 2396м.куб түлээ, хэрэглээний зориулалтаар 59 иргэнд 285м.куб модны эрхийн бичиг олгож 7493,5 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна. Сумын хэмжээнд иргэдийн түлшний хангамж 80 хувьтай хангагдсан байна.

Сумын үр тариа, тосны ургамал болон төмс, хүнсний ногооны ургац тогтоох ажлыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас өгсөн чиглэлийн зохион байгууллаа. Урьдчилсан ургац тогтоолтоор сумын дүнгээр үр тариа 9,1 цн-ээр тогтоож 1697 га талбайгаас 1555,8 тн ургац авах буюу 1054 га үр тарианы талбай ургац алдсан.Тосны ургамал 3 цн-ээр тогтоож 366,5 га-аас 109,6 тн ургац авах буюу 200 га талбай ургац алдсан.Төмс 119 цн-тээр тогтоож 260 га талбайгаас 3100 тн ургац, Хүнсний ногоо 137 цн-ээр тогтоож 84,5 га талбайгаас 1163,5 тн ургац авах буюу 25 га талбай ургац алдсан дүнтэй гарсан.

Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд мал, амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалгын ажлыг зохион байгуулж 44 өрхийн 18420 толгой бог мал хамрагдаад байна.

АДРА Монгол ОУБ-ын “Органик хөдөө аж ахуйн түншлэл” төсөлд хамрагдаж буй Сант сумын хоршоод, ногоочид өөрсдийн санаачилгаар хамтын баталгаажуулалтын байгууллага байгуулж, органик хүнс үйлдвэрлэлд шилжиж байгаагаар илэрхийлж, тангараг өргөх ёслолын арга хэмжээг зохион байгуулсан..

Тайлант сард сум хөгжүүлэх сангийн зээлийн эх үүсвэрээр мал аж ахуй салбарт 5, худалдаа үйлчилгээний салбарт 3 нийт 8 шинэ ажлын байр бий болсныг бүртгэж зуучиллаа.

СӨБ-ын хувилбарт сургалт буюу зуны гэр цэцэрлэг Ивэн 1-р багийн хөдөө “Хужрын толгой” гэдэг газарт 14 хоногийн хугацаанд нэг бүлгээр ажилласан ба 25 хүүхэд хамрагдаж хамран сургалтын хувийг нэмэгдүүлсэн байна.

Дэлхийн Зөн ОУБ-ын Сэлэнгэ нутгийн хөтөлбөрт амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 3 оюутны тэтгэлэгт сургалтын хөтөлбөрийг хөнгөвчлөх, зорилтот бүлгийн орон гэргүй 4 өрхөд гэр олгох материалыг бүрдүүлж хүргүүлээ. Зорилтот бүлгийн 31 иргэнд эд материалын дэмжлэг үзүүлж хувцас тараасан байна.

Хөдөөгийн хүн амд соёл урлаг, төрийн ажил үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор сумын ЗДТГ, Соёлын төв хамтран багийн “Малчдын өдөрлөг” арга хэмжээг 8-р сарын 05-ны өдөр Тэлдийн аманд зохион байгуулж цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл, бөхийн барилдаан, дааганы уралдаан, шагайн харваа, гар бөмбөг, олс таталтын тэмцээн зэрэг 6 төрлийн арга хэмжээ явагдаж 280 гаруй малчид, мал бүхий иргэд хамрагдсан байна.

Сумын Эрүүл мэндийн төвөөс “Эхийн сүүгээр хооллох бодлогыг дэмжих дэлхийн долоо хоног”- ийн хүрээнд “Энхрий үрс эрүүл торниход - Эцэг эхийн үүрэг чухал” уриан дор 7 хоногийн аяныг явуулж сургалт өдөрлөг зохион байгуулж 30 гаруй эцэг эхчүүд хамрагдсан.

Орхонтүүл сум

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын 2019 оны 05 тоот албан даалгаварын хэрэгжилтийг хангах зорилгоор сумын Засаг даргын захирамжийг гаргаж, төлөвлөгөөний дагуу 2004-2018 оны захирамж, тушаалыг скайнардан excel программ дээр шивж оруулах ажлыг хийж гүйцэтгэн албан даалгаварын хэрэгжилтийг холбогдох ажлын хэсэгт хүргүүллээ.

2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2019 оны 07 тоот албан даалгаварын дагуу сумын Засаг даргын 2019.08.13-ны өдрийн “Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” А/94 тоот захирамжийг

гаргаж, сумын байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж, албан даалгаварын заалтыг үүрэгжүүлэн, хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжигч” аяныг зохион байгуулах тухай сумын Засаг даргын захирамжийг гаргаж, суманд үйл ажиллагаа явуулж буй хэрчсэн гурилын 2, талх нарийн боовны 2, хоол үйлдвэрлэлийн 3, бууз баншны 1 газарт танилцуулж аянд нэгдэхийг уриалсан.

Рашаант тосгонд шинээр баригдаж буй 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил 90 хувьтай, дээврийн ажил, халаалт, сангийн ажлууд бүрэн дуусч, дотоод болон гадаад заслын ажлууд явагдаж байна.

Энэ сарын 16-18-ны өдрүүдэд ахмад тариаланчдын оролцуулсан ургацын урьдчилсан тогтоолт хийх ажлын хэсгийг байгуулан ажиллууллаа. Ургац тогтоолтын урьдчилсан дүнгээр сумын хэмжээнд улаанбуудай 1 га-аас дунджаар 10,6 цн, рапс 1 га-аас дунджаар 6,6 цн авах төлөвтэй байна. Нийт 800 га талбайн ургац алдсан нь тогтоогдсон ба үүнээс 200 га талбай нь мөндөрт, 600 га талбай нь ган гачигийн улмаас ургац алдсан байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 2019 оны намрын ургац хураалт удахгүй эхлэхтэй холбогдуудан жин хэмжүүрээ мэргэжлийн байгууллагаар баталгаажуулах талаар газар тариалан эрхлэгч аж ахуй нэгжүүдэд албан тоот хүргүүлээд байна.

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч даатгуулагчдаас 8 сарын 26-ны байдлаар 4335.0 мянган төгрөгний шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 12 даатгуулагчаас 663.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд иргэдийг хамруулан 8 иргэнтэй гэрээг шинэчлэн байгуулсан ба шинээр малчин-2, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн-2 иргэнийг хамруулан 2724.8 мян төгрөгний орлого орууллаа.

Тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь тавьж олгосон бөгөөд өндөр насны тэтгэвэрт-378 хүнд-129653.8 мян төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт-124 хүнд- 37480.8 мян төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 27 хүнд 7552.8 мянган төгрөг, цэргийн өндөр насны тэтгэвэр 3 хүнд-2191.8, цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр 1 хүн-404.5 мян төгрөг нийт 533 хүнд 151993.8 мян төгрөгийг харилцагч банкуудаар тус тус тавьж олголоо.

Ажилгүйдлийн тэтгэмжинд 1 хүнд 390,5 мян төгрөгийг хуваарийн дагуу харилцагч банкаар дамжуулан олголоо. Тэтгэвэр шинээр тогтоолгох хүсэлт гаргасан өндөр настан-5 иргэн, Жирэмсэн амаржсаны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авахаар хүсэлт ирүүлсэн 14 иргэний өргөдлийг хүлээн авч шийдвэрлүүлэхээр хэлтэст хүргүүлсэн.

Сүхбаатар сум

Аймгийн Засаг даргын 07 тоот албан даалгаврын дагуу сумын Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах албан даалгавар гарч харъяалагдах төр төсвийн байгууллага болон багуудад тараан өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг ханган 7 хоног бүр биелэлтийг тооцон ажиллаж байна.

Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцын талаарх мэдээллийг сонсон зарим сургууль цэцэрлэгт хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын явц гүйцэтгэлийн талаар харилцан ярилцах уулзалт зохион байгууллаа. Энэ хичээлийн жилд Сүхбаатар сумын ЕБС-ийн 1-р ангид 545 хүүхэд шинээр элсэн орж байна. СӨБ-д нийт хамрагдвал зохих хүүхдийн 95,0 хувь нь хамрагдаж байна.

Сүхбаатар сумын 80 жилийн ойд зориулан Хөтөлийн “Цементшохой” ХКомпани 60 тонн цементийг сумын Засаг даргын шийдвэрээр сургууль цэцэрлэгүүдийн авто зогсоол, гадна тохижилт, зам талбайг тохижуулахаар ажиллаж байна.

2019 онд улсын төсвийн 450 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Ирмүүн зам” ХХКомпани бордюр болон 1400м дугуйн зам, 3346 м² явган хүний замууд шинээр тавигдах ажил 50% гүйцэтгэлтэй явагдаж байна. Мөн ирэх 2020 онд Австри

улсын хөрөнгө оруулалтаар тус замуудын гэрэлтүүлгийн ажил хийгдэхээр төлөвлөгдөж байна. Уг бүтээн байгуулалтын ажлын явцтай Сүхбаатар сумын удирдлагууд танилцаж хяналт тавин ажиллалаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Буур хээр 8-р багт дулааны шугам татах ажлын төндөр зарлагдлаа. Мөн орон нутаг хөгжлийн сангийн 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Тохижилт үйлчилгээний газарт хог тээврийн машин худалдан авлаа.

УИХ-н гишүүн Н.Оюундарийн нэрэмжит “Иргэдийн спортын 2 дугаар наадам”-д Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Жавхлант, Хүдэр зэрэг 5 сум, Дулаанхаан тосгоны нийт 7 багийн 800 гаруй тамирчид Биеийн тамир спортын ордон, Спорт сургууль, Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулиудад 10 төрөлт спортоор хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Тэмцээнд Сүхбаатар сумаас 2 багийн 220 гаруй тамирчид оролцож, багийн нийлбэр дүнгээр Сүхбаатар 2-р баг тэргүүн байр, Сүхбаатар 1-р баг дэд байранд шалгарлаа.

Монголын мастеруудын спортын 5 дугаар наадам Хэнтий аймгийн Чингис хотноо зохион байгуулагдаж Сэлэнгэ аймгаа төлөөлөн 56 тамирчин спортын 6 төрөлд амжилттай оролцлоо. Спортын арга хэмжээнд оролцох тамирчдад сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 200.000 төгрөгний дэмжлэг үзүүллээ.

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооноос ирүүлсэн удирдамжийн дагуу Түшиг сумын “Өгөөмөрийн тал” хэмээх газар зохион байгуулагдсан “Хамтдаа хөгжье” зуны аялалд сумын хөгжлийн бэрхшээлтэй 10 хүний бүрэлдэхүүнтэй багийг оролцуулсан.

АДРА олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Органик хөдөө аж ахуй” төсөлд “Мөнхцовдон” хоршоо органик төмс, хүнсний ногоо, зөгийн аж ахуй төсөлд хамрагдан төмс, хүнсний ногоо тариалагч 4, зөгийн аж ахуй эрхлэгч 6 иргэн эрүүл органик хүнс үйлдвэрлэгчээр тодорч “Тангараг” өргөлөө.

Хушаат сум:

Атар газар эзэмшсэний 60 жилийн ойд зориулан сумын ахмад настан, ахмад тариаланч Б.Нямаагийн “Эргэн дурсахуй” номоос сэдэвлэн хөрөг нийтлэлийг аймгийн ЗДТГ-ын “Өргөн Сэлэнгэ” сэтгүүлд нийтлүүлж, сумын “Нээлттэй Хушаат” вэб хуудас, “Хушаатын мэдээ” сонинд нийтэлж олны хүртээл болголоо.

Сумын хэмжээнд хийгдсэн ургац тогтоолтын дүнгээр үр тариа тариалсан 11171 га-гаас 1873 га талбай актлагдахаар байгаа бөгөөд үүнээс 198 га мөндөрт цохигдсон 1675 га ганд нэрвэгдсэн. Эцсийн дүнгээр нийт 9100 га талбайгаас 13134.0 тн ургац хураан авахаар байна. Үүнээс: Улаанбуудайн 8619 га-гаас 12552.0 тн буюу 1 га-гаас 14.6 цн ургац хураан авахаар байна. Тэжээлийн ургамал 351 га-гаас 569.0 тн /16,2 цн/ рапс 2722 га-с 1527,0 тн /5,6 цн/ төмс 245,1 га-с 3096,1 тн /126,3 цн/, хүнсний ногоо 238,2 га-с 2943,3 тн /123,6 цн/ ургац тус тус хураан авахаар тогтоосон. 8539 га уринш үүнээс 3500 га химийн, 5039 га механик уринш хийсэн.

2019.08.06-ны өдөр сумын “Элит үр” ХХК буурцагт ургамлын тариалалтын технологи, буурцагт ургамлын үрээр хийсэн бүтээгдэхүүний талаар 6 аймгийн тариаланчид оролцсон сургалт, талбайн үзүүлэх сургалт зохион байгуулагдлаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орхон голын гүүрнээс сумын төвийн дунд хүртэл хайрган хучилттай замын ажил, ЕБС-ийн их засварын ажлууд хийгдэж байна.

Тайлант сард Улсын бүртгэлийн тухай, Иргэний бүртгэлийн тухай хууль бусад холбогдох хууль журмын хүрээнд нотлох баримтуудыг үндэслэн дараахь бүртгэлүүдийг хийлээ. Төрөлт 5, эцэг тогтоолт 2, гэрлэлт 1, шилжин ирсний 7, өөр аймаг хотоос 3, баг хооронд 4, нас барсны 1, биеийн давхцахгүй өгөгдлийн 9, газар өмчлөх эрхийн анхны бүртгэл 12, иргэний үнэмлэх олголтын 5, нийт 42 бүртгэл хийж 7 гэрчилгээ бичиж олгов. Төрийн сан банкны орон нутгийн дансанд 36700, УБХ-ийн дансанд 152000 төгрөгийн орлого оруулсан байна.

Сумын ЭМТ-д нас баралт 2, ор хоног 86, эмнэлэгт хэвтсэн 14, эмнэлгээс гарсан 15, үзлэгийн тоо бүгд 120, амбулатори 80, урьдчилан сэргийлэх 18,

идэвхитэй хяналт 12, гэрийн идэвхитэй үзлэг 10, хяналтанд байгаа жирэмсэн 18, шинээр хяналтанд орсон 2, 0-5 насны жинэлсэн хүүхдийн тоо 160, түргэн тусламжийн дуудлага 59, үүнээс алсын дуудлага 12, артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 54, чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 54, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүүхдийн тоо 36, шинжилгээнд хамрагдсан хүний тоо 115, умайн хавдар хөхний хавдар илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 29, элэгний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 54 хүн байна.

Бүрэн дунд боловсролын сайжруулсан хөтөлбөр хэрэгжүүлж ажиллахаар сургуулийн 20 багш, 3 удирдлага 8-р сарын 15-18-ны хооронд аймгийн төвд сургалтанд хамрагдаж, хичээлийн шинэ жилийн бэлтгэлийг хангаж, багш боловсон хүчнээр 100 хувь хангагдсан.

Хүдэр сум:

Тайлант сард сумын эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн үйлчилгээг стандартын дагуу үйлчилж, дархлаажуулалтын товлотт вакцинд 45 хүүхдийг хамруулсан.

Сумын соёлын төвөөс 10 ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, 454 иргэн үйлчлүүлсэн. Бүжгийн дугуйланд 12 сурагч тогтмол хичээллэж байна.

Мал амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Шанд, Уялгын чиглэлийн айл өрхүүдэд зохион байгуулж, угаалгын ваннд нийт 9100 бог малыг орууллаа.

Сумын ургац хураалтын урьдчилсан дүнг гаргах ажлыг хэсгийг томилон ажиллж, дүнг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Ой хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу 4 удаа зохион байгуулж, 6 аж ахуйн нэгжид 500 нэгжийн торгуулийн арга хэмжээ авч, 20 м3 нарсан гуалинг хураан авсан.

Хууль бусаар ашигт малтмал олборлолтыг шалгах аймгийн ажлын хэсэг тус суманд ажиллаж, холбогдох арга хэмжээ авч ажиллалаа.

Жавхлант сум:

Тайлант сард сумын Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа, төр төсвийн байгууллагуудын дарга эрхлэгч болон албан хаагчдын шуурхай хурал 2 удаа боллоо.

Байгууллага сурталчлах сарын аяны хүрээнд сумын Засаг даргын Тамгын газар, “Дэлхийн зөн Олон улсын байгууллага”-ын Сэлэнгэ нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран сумын зорилтот бүлгийн иргэнд иж бүрэн таван ханатай гэр олголоо. Мөн Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс Улаанбаатар хот, Хэнтий аймаг, Хэнтий аймгийн Биндэр сумаар туршлага судлах аялалыг зохион байгуулж, тус сумын “Өрхийн хөгжил-90” хөтөлбөрт хамрагдсан 6 иргэн оролцож туршлагаа солилцсон.

Улсын их хурлын гишүүн Н.Оюундарийн нэрэмжит “Биеийн тамир, спортыг айл өрх, иргэн бүрт хүргэх” Төвийн бүсийн иргэдийн спортын наадам, Түшиг суманд зохион байгуулагдсан “Хамтдаа хөгжье” уриан дор болсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд явагдсан уралдаан тэмцээнд сумын иргэдийг оролцууллаа.

Тайлант сард эрүүл мэндийн төвөөс нийт 349 үзлэг хийж, иргэдэд хөнгөлөлттэй жороор 23 иргэнд үйлчилж зөвлөгөө өгч, 18 иргэн хэвтэн эмчлүүлсэн. Мөн товллын дагуу дархлаажуулалтанд 16 хүүхдийг хамруулсан.

Өвөжилтийн бэлтгэл ажилд бэлтгэн дотуур байрны сурагчдын тав тухтай, таатай, эрүүл цэвэр орчинд хооллох орчинг бүрдүүлэх зорилгоор дотуур байрны гал тогооны хана шалыг бүтэн плитадах засварыг ажлыг эхлүүлж, биеийн тамирын гадна талбайд өнгө сэргээх засвар ажлыг хийж гүйцэтгэлээ.

Атар газар эзэмшсэний 60 жилийн ойг тохиолдуулан “Хүндэт дэвтэр, Хүндэтгэлийн туг”-ийг Мандал сумаас хүлээн авч Атар 60 хүндэт тугийг Бумбат 1-р баг, Моностой 2-р багин өдөрлөгөөр аялуулан Ерөө суманд хүлээлгэн өглөө.

Түүхийн хүндэт дэвтэрт атрын 1, 2, 3-р аянд ажиллаж хөдөлмөрлөж явсан ахмад тариаланчид гарын үсэг зурж мөнхөллөө.

Намрын ургац хураалтын ажил эхэлж байгаатай холбогдуулан ХХААХҮЯамны Газар тариалангийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Болорчулуун, Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн захирал Н.Баярсүх, аймгийн агрономич нар аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, тариалангийн талбайн ургацтай газар дээр нь үзэж танилцлаа.

Газар зүй, Гео экологийн хүрээлэнгийн ажилтнуудтай хамтран “Залан Хайдав”-ын рашаанаас усны дээж, ундарга, усны гарцын дээж авч судалгаанд хамруулсан.

Аймгийн хөрөнгө оруулалтаар “Цагаан даваа”-ны булгийн эхийн модон хашаа муудаж эвдэрсэн тул төмөр хашаа барьж, “Хоггүй цэвэрхэн Монгол” аяны хүрээнд Шарын голын эрэг дагуу 3 га газрын хог хаягдлыг төр төсвийн байгууллагын албан хаагчидтай хамтран цэвэрлэж 2 тн хог хаягдлыг хогийн төвлөрсөн цэгт хаяж зайлуулсан.

Тайлант сард төрсний бүртгэл 5, шилжилт хөдөлгөөн 2, иргэний үнэмлэх олголт 3, гэрлэлтийн бүртгэл 1, шинээр иргэний үнэмлэх 7, иргэний үнэмлэх дахин авалт 2, нийт 19 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

Нийгмийн даатгалын сангаас 2019 оны 7-р сард өндөр насны тэтгэвэр авагч 228 иргэнд 73886.4 мянган төгрөг тахир дутуугийн тэтгэвэр авагч 75 иргэнд 21188.7 мянган төгрөг тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 13 иргэнд 3616.9 мянган төгрөг цэргийн тэтгэвэр авагч 3 иргэнд 1625.7 төгрөг ажилгүйдлийн тэтгэмжинд 1 иргэнд 493.2 мянган төгрөг, ХЧТА тэтгэмжинд 2 иргэнд 125,3 мянган төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжинд 1 иргэнд 1121,9 мянган төгрөг, оршуулгын тэтгэмжинд 1 иргэнд 1000 төгрөг тус тус олгон ажиллалаа.

Улсын төсвийн 44 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар соёл амралт, биеийн тамирын талбайг барьж байгуулах ажлын тендер аймгийн ОНӨАлбанд зарлагдаж гүйцэтгэгчээр “Урантөмөр хэлхээ” ХХК шалгарч ажлаа хийж дуусгаад байна.

“Нэг иргэн-нэг бүртгэл” хөтөлбөрийн хүрээнд улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох ажил тус аймагт хийгдэх гэж байгаатай холбогдуулан шаардлагатай тоног төхөөрөмжийн үнэ 2250,0 мянган төгрөгийн асуудлыг шийдвэрлэх саналыг аймгийн Засаг даргад хүргүүлж, төсвийн байгууллагуудын эдэлгээний хугацаа дууссан болон ашиглах боломжгүй 99,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж устгах асуудлыг сумын ИТХурлаар хэлэлцүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Түшиг сум:

“Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийнн улсын үзлэг”-т бэлтгэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж, аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

2019 онд Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй “60 хүүхдийн дотуур байр барих” ажлыг “Чингисийн төгөл” ХХК гүйцэтгэж, гүйцэтгэлийн ажил 55 хувьтай, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумын Засаг даргын Тамгын газрын гадна засварын ажлыг “Сүлд ханба” гүйцэтгэж, байнгын ашиглалтанд хүлээлгэн өгөөд байна. Мөн сумын төвийн 1,8 км цементэн хучилттай болох замын ажлыг “Шар нарст” ХХК, “Техноперспектив” ХХК-ний дэмжлэгтэйгээр хийж, “Бооцын тариа” ХХК, “Анхтамир” ХХК-иуд өөрсдийн санаачлагаар “Хүүхдийн тоглоомын талбай”, “Атар 60 хүндэтгэлийн хөшөө” зэргийг сэргээн засварлалаа.

Сумын Засаг даргын 2019 оны А/56 тоот захирамжаар ургац тогтоолт явуулах ажлын хэсгийг байгуулж, нийт 12656 га талбайн ургацыг тогтоож, урьдчилсан байдлаар сумын дүнгээр нэгж га талбайгаас 10,5 цн ургац хураан авах төлөвтэй байна.

Сумын хэмжээнд нийт 60 малчин өрх 15,4 мянган тонн хонины ноосыг “Жи Эс Эф” тушааж, аймгийн ХХААГ-т тайлан мэдээг хүргүүлээд байна.

Сумын Засаг даргын 2019 оны А/59 тоот захирамжаар “Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг”-ийг Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулж, төр төсвийн байгууллагууд, халаалт дулаан нийлүүлдэг аж ахуйн нэгжийн өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцаж, байгууллагын удирдлагуудад үүрэг чиглэлийг өглөө. Халаалт дулаан нийлүүлж буй “Зоригт Алтай” ХХК нүүрс худалдан авахаар Улаан-Овоогийн нүүрсний уурхайтай гэрээ байгуулж, өөрийн галлагаатай сумын ЗДТГ, Соёлын төв 1 сарын түлшний нөөцтэй байна.

Багийн иргэдийн Нийтийн Хурлыг 8-р сарын 10-ны өдөр зохион байгуулж, малчин, мал бүхий өрх, аж ахуйн нэгжийн бэлтгэх хадлангийн газрыг хуваариллаа. 2019 онд сумын хэмжээнд 980 тонн байгалийн хадлан бэлтгэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Малчин өрхүүдэд тариалангийн талбайд мал оруулахгүй байх, заасан хугацаанаас өмнө намаржааны газар буухгүй байх анхааруулгыг 85 малчин өрхөд өгсөн.

Цагааннуур сум:

Монгол Улсын начин Баярсайханы Орхонбаярын цолны мялгаага наадмыг энэ сарын 10-11-ний өдрүүдэд зохион байгуулж, сагсан бөмбөг, гар бөмбөг, “Сайхан морьтой хос” тэмцээн, “Дээлтэй Монгол наадам” болон хурдан морьдын уралдааныг тус тус зохион байгууллаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат тус сумын Оргих 1-р багт малчдын бэсрэг наадмыг зохион байгуулснаас гадна багийн малчдын өдөрлөгийг 8-р сарын 22, 23-ны өдөр зохион байгуулж, нийгмийн даатгал, улсын бүртгэл, байгаль хамгааллын хууль тогтоомж, ЕБС, цэцэрлэгийн бүртгэлийг талаар мэдээлэл өглөө.

Тайлант сард нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас өндөр настан 398 иргэнд 132199,1 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэмжинд 54 иргэнд 15652,0 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 225 иргэнд 73461,7 мянган төгрөг, цэргийн өндөр настан 4 иргэнд 2393,0 мянган төгрөг, Үйлдвэрлэлийн осол, мэргэшлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 4 иргэнд 1277,6 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1 эхэд 1807,3 мянган төгрөгийг олгож ажилласан.

Усны тоо бүртгэлийн ажлаар Тийрэг, Рашаант, Моностой, Харгистай, Салхит, Оргих, Баруун гол, Нянгай, Өгөөмөр, Нарийн шүрэн, Гүншүрэн, Үүцэг, Согооч, Хуурч, Жаргалант, Ноён уулын булаг зэрэг газруудын худаг усыг бүртгэсэн.